



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.17 № 489

танай 2024.07.16 -ны № 18 -т

ХАЛХГОЛ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХАЛХГОЛ  
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА Х.ХҮРЭЛ-ЭРДЭНЭ  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Дорнод аймгийн Халхгол сумын МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011021348

### **Дүгнэлт**

Халхгол сумын Монгол ардын намын хорооны Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дорнод аймгийн Халхгол сумын МАН-ын мөрийн хөтөлбөр 11 (хуудас)-ыг хавсаргав.

Хувийг: Халхгол сумын Монгол ардын намын хороонд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 11 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ


Халхгол сумын Монгол Ардын Намын  
Бүх гишүүдийн хурлын 2024 оны  
...сарын...өдрийн...дугаар  
тогтоолын ... хавсралт

**СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ 2024 ОНЫ  
СОНГУУЛЬД ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, “Дорнод сэргэн мандалт” хөгжлийн хөтөлбөр, “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт”, Дорнод аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналуудад үндэслэн 2024-2028 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрөө тодорхойлж байна.

Дорнод аймгийн Халхгол сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа хүн амын нутагшилт, суурьшилт тогтвортой, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, аялал жуулчлалын хөгжлийг олон улсын жишигт хүргэх, эдийн засгийн чадавхыг сайжруулж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж иргэнд ээлтэй амьдрах орчин, амар тайван аюулгүй нийгмийг бүтээх замаар сум, орон нутгийг хөгжүүлэх, Халхгол сумын Монгол ардын намын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлсэн бодлогын залгамж чанарыг хадгалж дараах зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүллээ.

**Зорилго:** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байгалийн үзэсгэлэн, хилийн боомтуудаа түшиглэсэн зүүн бүсийн аялал жуулчлалын голлох тулгуур болон хөгжүүлж, чинээлэг дундаж давхаргыг нэмэгдүүлэн эрүүл чийрэг, аз жаргалтай, **ХҮНИЙ ХӨГЖЛӨӨР ТЭРГҮҮЛСЭН СУМ** болох.



## НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Хүн бүрд эрүүл мэндийн үйлчилгээ, хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах, хөгжих боломжийг бүрдүүлнэ.**

**Зорилго 1.** Эрүүл мэндийн салбарт орчин үеийн оношлогоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

1.1. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

1.1.1. Иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.

1.1.2. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд орон нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.

1.1.3. Нарийн мэргэжлийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг бэлтгэх, хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.

1.1.4. Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, чадавхийг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.

1.1.5. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.

1.1.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл хяналтыг сайжруулна.

1.1.7. Алслагдсан малчин өрх, хилийн сумангуудын иргэдэд нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улирал тутамд чанартай хүргэх ажлыг зохион байгуулна.

1.1.8. Ялалт багийн эмнэлгийн ажиллах нөхцөл бололцоог сайжруулж иргэдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.


1.1.9. Монгол улсын Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг сумандаа хэрэгжүүлнэ.

1.1.10. Багийн эмч хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

**Зорилго 2.** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ.

2.1. Хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээ, оюуны чадвар өндөр, дасан зохицох чадварт суралцуулж, түүх өв соёлоо хамгаалах чанарыг хэвшүүлж, хүүхдийг бага наснаас нь төлөвшүүлнэ.

2.1.1. Нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлж, сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 90 хувьд хүргэнэ.



2.1.2. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн багшийн нөөцийг төлөвлөх, дутагдалтай мэргэжлээр сургах тэтгэлэгт хамруулахад анхаарч нийгмийн баталгааг сайжруулахад санаачлага гарган ажиллана.

2.1.3. Сурагчдын оюуны чадавхыг хөгжүүлэх, сурах арга барил эзэмшүүлэх “Оюуны спортын төв” байгуулж оюуны спортыг орон нутагтаа хөгжүүлнэ.

2.1.4. Сургалтын хөтөлбөрөөс гадна монгол хэл, бичиг, түүх өв соёлын боловсролыг сурагчдад чанартай эзэмшүүлнэ.

2.1.5. Элсэлтийн ерөнхий шалгалт, олимпиадад амжилт үзүүлсэн багш, сурагчдыг дэмжиж ажиллана.

2.1.6. Улс болон бүс, аймгийн чанартай тэмцээн, уралдаанд амжилт гаргасан тамирчдыг дэмжиж ажиллана.

2.1.7. Улс, аймаг, бүсийн чанартай урлаг, соёл, спортын тэмцээн, уралдааныг орон нутагтаа зохион байгуулна.

2.1.8. Сургууль, цэцэрлэгийн хүүхэд, багш, ажилчдад нийтийн тээврийн унаагаар үйлчилнэ.

2.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалт хийх, мэргэшсэн багшийг бэлтгэж, чадавхжуулна.

2.1.10. Өсвөр насны хүүхдийг амьдрах ухаанд сургаж төлөвшүүлэх зорилготой хөдөлмөр амралтын зуслан байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.1.11. Монгол Улсын Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан боловсролын хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.

**Зорилго 3.** Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжиж, үндэсний бахархал, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэх, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1. Эх хэл, түүх, өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай эх оронч үзлийг хүүхэд залуучууд, иргэдэд эзэмшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлнэ.

3.1.1. Соёлын байгууллагуудын уран бүтээлд үндэсний бахархлыг сэргээх агуулгыг тусган хэрэгжүүлнэ.

3.1.2. Ялалт музейн сан хөмрөгийг баяжуулж, үзмэр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, орчин нөхцлийг сайжруулна.

3.1.3. Иргэд олон нийтийн оролцоотой соёлын биет биет бус өвийг хамгаална.

3.1.4. Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.


3.1.5. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ.

3.1.6. Суман дахь Хээрийн музей, орон нутгийн музейд түүх, соёлын өвийн сургалт танин мэдэхүй, аялал жуулчлалын төв байх зорилтыг хэрэгжүүлнэ.

3.1.7. “Их бурхант”, “Хүүхдийн овоо” гэх мэт түүхийн үнэ цэнэтэй газруудыг хамгаалах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үргэлжлүүлж, гадна болон дотоодын аялагчдад таниулах ажилд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

3.1.8. То вангийн сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

3.1.9. Ялалт хөшөөний цогцолбор байгуулна.



3.1.10. Хүүхэд залуучууд, иргэдэд уламжлалт өв соёл, ес зүй, байгаль экологи, түүх, гадаад хэл, урлагийн боловсрол олгох, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.1.11. Залуучуудын чөлөөт цаг өнгөрүүлэх, фитнес төвтэй болно.

3.1.12. ТАХ-ын байрны засвар үйлчилгээ, хуучин спорт заал, урлаг заалыг хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх төв болгон тохижуулна.

3.1.13. Халхгол бүс нутгийн судалгаа шинжилгээний ажлыг гадаад дотоодын байгууллагатай хамтран хийж гүйцэтгэн олон улсын "Эрдэм шинжилгээний хурал" зохион байгуулна.

3.1.14. Соёл урлагийн салбарт мэргэжлийн боловсон хүчнийг мэргэшүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.1.15. Суманд биеийн тамирын арга зүйч ажиллуулж, нийтийн биеийн тамир, багийн спортоор хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

3.1.16. Суманд өвлийн спортоор хичээллэх тохь тухтай таатай орчныг бүрдүүлэх байгууллага, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

3.1.17. Сумын наадмын талбайн ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх орчин бүхий нийтийн биеийн тамирын спортыг хөгжүүлнэ.

3.1.18. Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг дээшлүүлэхэд анхаарна.

3.1.19. Монгол Улсын Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан соёлын хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.

**Зорилго 4.** Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг дэмжинэ.

4.1. Нийгмийн халамжийг оновчтой хуваарилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн гэр бүл хамгааллыг сайжруулна.

4.1.1. Хөгжих, хамгаалуулах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд нэг бүрт тэгш, хүртээмжтэй хүргэдэг "Хүүхдэд ээлтэй сум" болно.

4.1.2. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиг үүргээр ажилладаг "Хамтарсан баг"-ийн чадавхыг бэхжүүлнэ.


4.1.3. Өрх бүрт "Угийн бичиг"-ээ хөтөлж, удмын түүх, ургийн хэлхээгээ өвлөн уламжлах, соёлд сургаж, хэвшүүлнэ.

4.1.4. Хүүхдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх, клуб, дугуйлангууд, хүүхдийн байгууллагуудын нэгдсэн хамтын ажиллагааг бодлогоор дэмжиж, хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.5. Хүүхдийн тоглоомын талбайнуудын стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэн, хяналтыг сайжруулна.

4.1.6. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдэд нийгмийн хамгаалал, хууль, эрх зүйн дэмжлэг үйлчилгээ үзүүлдэг орчин бүрдүүлнэ.

4.1.7. Залуу гэр бүл, хүүхэд, залуус шинээр иргэний үнэмлэхээ авах, иргэний андгай өргөх, гэрлэлтээ батлуулах, шинэ хүүхдэд төрсний гэрчилгээ олгох зэрэг төрийн ёслол, хүндэтгэл үзүүлэх өргөөтэй болно.



4.1.8. Төрийн болон эрүүл мэнд, боловсрол, соёл, худалдаа үйлчилгээ, мэдээлэл авах зэрэг үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх байдлыг сайжруулна.

4.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулж нэмэлт орлоготой болгоход дэмжлэг үзүүлнэ.

4.1.10. Нийгмийн салбарт хэрэгжиж буй дээд шатны байгууллагуудын бодлого, хүүхэд залуучууд, ахмад настны талаарх төсөл, хөтөлбөрүүдийг орон нутагт бүрэн хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлт, халамж үйлчилгээг дэмжинэ.

## **ХОЁР ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

**Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй бодлогыг хэрэгжүүлэн салбарын чадавхыг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.**

**Зорилго 1.** Санхүү, эдийн засгийг тогтвортой байлгаж, иргэдийн амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлж, төсвийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.

1.1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд саадгүй хүргэх, татварын суурийг нэмэгдүүлнэ.

1.2. Санхүү албаны ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ажиллах нөхцөл, нөөцийн бүрдүүлэлтийг дэмжинэ.

1.3. Төсвийн сахилга батыг сайжруулж, дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлж, төсвийн харилцааг бүх шатанд ил тод, нээлттэй байх зарчмыг сайжруулна.

1.4. Хувьчлалдан авах ажиллагаанд оролцогчдыг чадавхжуулан, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, хөндлөнгийн хяналтыг сайжруулж, хуулийн шаардлага хангасан орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

1.5. Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, өмчийн бүртгэл мэдээллийг цахимжуулан орон нутгийн өмчийн хяналтыг сайжруулна.

1.6. Орон нутгийн өмчид бүртгэлтэй, ашиглагдахгүй байгаа барилга, байгууламсыг ашиглан ажлын байр нэмэгдүүлнэ.


1.7. Төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн худалдан авалтаар дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжинэ.

**Зорилго 2.** Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, орон нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгаас бүрэн хангах талаар бодлого хэрэгжүүлнэ.

2.1. Орон нутгаанд мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний бие даасан нэгж байгуулна.

2.2. Байгалийн нөхөн сэргээгдэх баялаг болох өвс, тэжээл бэлтгэлийг технологийн дагуу нэмэгдүүлж, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн бүтээгдэхүүний улс болон бүс, бусад аймаг сумын хэрэгцээнд нийлүүлнэ.

2.3. Малын үүлдэр угсааг сайжруулах, мал үржүүлэг технологийн аж ахуйг бодлогоор дэмжинэ.



2.4. Малчин, тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллана.

2.5. Малжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.6. Бэлчээрийг усжуулах цэг, мал тарилгын хашаа, угааврын ванныг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, малын бэлчээрийн нөөц газрыг нэмэгдүүлнэ.

2.7. Малын хавар, намрын ангилалтын зардлыг сумын төсөвт тусгана.

2.8. Дайгын аж ахуй эрхлэлтийг дэмжих, цэвэр зөгийн балаар аймаг, сумын хэрэгцээнд нийлүүлэхээс гадна БНХАУ-ын хил залгаа аймгуудад экспортлох боломжийг бүрдүүлнэ.

2.9. Амшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга, цас бороо гэх мэт) цар тахал гоц халдварт өвчний тархалт, давтамж, орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, аюулын судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.10. Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах зорилгоор сумын өвс тэжээлийн аюулгүйн нөхц бүрдүүлэлтийг нэмэгдүүлнэ.

2.11. Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно мэрэгч амьтадтай байгаль оргод халгүй аргаар тэмцэнэ.

2.12. Урьс шир, ноос ноолуур боловсруулах цехтэй болно.

2.13. Мөнэ хоршоо хөдөлгөөнийг үргэлжлүүлэн дэмжиж ажиллана.

**Зорилго 3.** Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг суманд хэрэгжүүлж, халдварт өвч халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй тайван бүсийг баталгаажуулж, малын түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулна.

3.1. Мал сүрэгт гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын ажлыг хэрэгжүүлж, өвчлөлийг бууруулна.

3.2. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулан баталгаажуулна.

3.3. Халдваргүй өвчний оношилгооны чадамжийг нэмэгдүүлж, эрт оношлох урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулна.

3.4. Мал эмнэлгийн тасаг болон хувийн мал эмнэлгүүдийн чадавхыг сайжруулж боловсон хүчний нөөцийг бүрдүүлнэ.


**Зорилго 4.** Газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

4.1. Газрын баялаг нөөцөл тулгуурлан, нэгж талбайгаас хураан авах ургацын хэмжээ, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлнэ.

4.2. Талгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

4.3. Тариалангийн талбайн хөрсний элэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зурваслан гэд тарих ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

4.4. Тариал, жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо, малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх тариалах газрыг хуулийн хүрээнд давуу эрхээр эзэмшүүлэх бодлого баримтасна.



4.5. Хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор хүлэмж, зоорийн аж ахуйг хөгжүүлнэ.

4.6. Ногоочдыг дэмжих зорилгоор орчин үеийн хөдөлмөр хөнгөвчлөх тоног төхөөрөмжөөр хангах, гэр хороололд гүний худаг, усалгааны шугам татах санаачлагыг дэмжиж ажиллана.

**Зорилго 5.** Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах бичил, жижиг дунд үйлдвэрлэл, ахуй үйлчилгээг хөгжүүлж, үйлдвэрлэлийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэн гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1. Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах бичил, жижиг дунд үйлдвэрлэл байгуулахыг бодлогоор дэмжинэ.

5.2. Орон нутгийн түүхий эдэд тулгуурлан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зарлуулалт нэмэгдүүлэх чиглэлээр кластерын мэдлэг олгох сургалтад бизнес эрхлэгчдийг хамруулна.

5.3. Суманд нутгийн брэнд бүтээгдэхүүн худалдаалах цэгтэй болно.

**Зорилго 6.** Байгалийн болон түүх, соёлын нөөцөд тулгуурлан дотоод гадаадын аялал жуулчлал, дагалдах үйлчилгээний салбар, дэд бүтцийг хөгжүүлнэ.

6.1. Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг ил тогтооно, иргэдийн орлогыг сайжруулна.

6.2. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулан үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хөгжүүлнэ.

6.3. Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний газар байгуулна.

6.4. Улирын Баянхошуу болон Сүмбэр Рашаантын боомтын цогцолборыг шинээр баруулах байгуулна.

6.5. Рашаант-Халхгол сумын дунд Алтанголын гүүрийг шинээр барина.

6.6. Аялал жуулчлалд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.

6.7. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг орчин үеийн байгаль ээлтэй, дэвшилтэт технологиор сайжруулж, аялагч, жуулчдыг сэтгэл ханамжтай, тав тухтай аюулгүй таслан аялах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.


6.8. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд бүрэн хамруулж, эко ариун цэврийн байгууламжтай болгоно.

**Зорилго 7.** Ил тод хариуцлагатай уул уурхайн салбарын хууль, тогтоомж бодлогын гүйцэтгэлийг орон нутагт хангаж ажиллана.

7.1. Уул уурхайн лицензийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлнэ.

7.2. Уул уурхайн тос, ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн хариуцлагыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ил тод хөгжлийг дэмжих арга хэмжээний хяналтыг сайжруулна.

7.3. Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг хайгуулын нөөц ашигласан төлбөрөө хугацаанд нь төлдөг хариуцлагатай уул уурхайн орон нутгийн түвшинд дэмжинэ.



7.4. Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийг тул уурхай, газрын тосны үйл ажиллагаанд давуу эрхтэйгээр бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

**Зөрчилгөө 8.** Цахилгаан дулааны эрчим хүчний найдвартай аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.

8.1. Сумын төв, хорооллын айл өрхийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцийг өргөтгөнө.

8.2. Сумын уурын зуухны хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлнэ.

8.3. Тогтмол багийн агаарын шугамын өргөтгөлийн ажлыг хийнэ.

**Зөрчилгөө 9.** Орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл технологийн үйлчилгээг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж бүрт хүргэх нөхцөлийг сайжруулна.

9.1. Сумын шилэн кабелийн сүлжээг өргөжүүлнэ.

9.2. Сумын үүрэн холбооны сүлжээний тархалтыг сайжруулна.

**Зөрчилгөө 10.** Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлнэ.

10.1. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлыг хэрэгжүүлнэ.

10.2. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хөгжлийн төлөлттэй сууринг тодорхойлж, иргэнд газар өмчлүүлэх газрын нөөцийг тогтооно.

10.3. Газрын цахим биржийн үйл ажиллагааг тогтмолжуулж, иргэдэд газар, үл хөдлөх эзэмшилтийн нэгдсэн мэдээллийг нээлттэй хүргэнэ.

10.4. Газар зүйн нэрийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

10.5. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй болгоно.

## ГҮРЭНГЭ УХААЛАГ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО


Бүх нийтийн төрийн байгууллага, төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлж, төрийн байгууллын шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үр дүнтэй зохион байгуулж, үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.

**Зөрчилгөө 1.** Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг хөгжүүлж, сахилга хариуцлагыг дэмдэжүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод нээлттэй хүргэнэ.

1.1. Төрийн үйлчилгээг нэг цэгээс цаг хугацаа алдалгүй шуурхай авах боломжийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний операторын үйлчилгээ /E-MONGOL/ -ийг өргөжүүлнэ.

1.2. Төрийн байгууллагуудын зарим үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төрийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангана.

1.3. Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулж, ажлын байранд сурган, хөгжүүлэх, салбар байгууллага хооронд туршлага солилцох ажлыг хэрэгжүүлнэ.



1.4. Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэн бүрдүүлэх, шинээр төрийн албанд томилогдсон албан хаагчдыг сурган чадавхжуулна.

1.5. Суманд нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад "Нутгийн ирээдүй" төслийг үргэлжлүүлэн дэмжиж ажиллана.

1.6. Төрийн албан хаагчдыг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих ажлыг тогтмол хэрэгжүүлнэ.

1.7. Сумын төвд төрийн албан хаагчдын орон сууцны шинэ хороололтой болно.

1.8. Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн зөрчлийн нэгдсэн бүртгэлийг сайжруулж, албан тушаалаа урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

1.9. Төрийн үйлчилгээнд Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг бүрэн нэвтрүүлнэ.

**Зөвлөгөө 2.** Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангаж, орон нутагт хуулийн хэрэгжилтийг хангуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн сургалтыг иргэд, олон нийтэд болон төрийн албан хаагчдад зохион байгуулна.

2.2. Иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах дүнтэй тэмцэх ажилд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

2.3. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гишүүдийн оролцоог идэвхжүүлнэ.

2.4. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

2.5. Даршилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

**Зөвлөгөө 3.** Батлан хамгаалах салбарын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлийн үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх, сургалт бэлтгэлийг хангах, томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлнэ.

3.1. Хугацаат цэргийн алба хаах иргэдэд Цэрэг Эх оронч үзлийг төлөвшүүлэн, эрүүл мэндийг сайжруулж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

3.2. Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэх, сургалт бэлтгэлийг зохион байгуулна.

3.3. Цэргийн албанд татагдаж болон халагдаж ирж байгаа залуучуудад хүндэтгэл үзүүлнэ.

**Зөвлөгөө 4.** Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлж, Хяналт шинжилгээ, үнэлгээг зохион байгуулна.

4.1. Хяналт байгууллагуудын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдалд сумын Засаг дарга баталсан удирдамжийн дагуу Хяналт шинжилгээ үнэлгээ хийж үйл ажиллагааг сайжруулахад мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

4.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр нөлөөг орон нутагт бүрэн хэрэгжүүлж ажиллана.

2117144066  
ХТҮ4037 9030891

## ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгаль орчныг хамгаалах оновчтой менежментийг хэрэгжүүлснээр доройтсон орчныг нөхөн сэргээж ойжуулах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж ирсэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

**Зорилго 1.** Ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, хүн, амьтны эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

1.1. Цэржилтэд хүчтэй өртөж байгаа газар нутагт ганд тэсвэртэй тухайн орчинд тохирсон мод бут тарьж ойн зурвасыг нэмэгдүүлэх зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2. Хэвэр ан амьтан ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулна.

1.3. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайг нөхөн сэргээнэ.

1.4. Тал ой хээрийн түймэрт шатсан талбайд ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийнэ.

1.5. Буйр нуурыг улсын тусгай хамгаалалтад авах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.6. Бэлчээрийн даац, доройтлыг нарийвчлан тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

1.7. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

1.8. Буйр нуурын элсний нүүдлээс хамгаалах зорилгоор нутгийн малчид, мал бүхий иргэдтэй хамтран ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

1.9. Байгаль цаг уурын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.

1.10. Суманд ойн хортон хөнөөлт шавьж, өвчнөөс урьдчилан сэргийлэх судалгаа тогтмол явуулж, илэрсэн орчинд тэмцлийн ажлыг зохион байгуулж, байгаль орчинд халгун биологийн аргаар хэрэгжүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

1.11. Сум дундын ойн ангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, чанартай үр, тарьц, суулгацаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.12. Рашаан, булаг, шандын эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлнэ.

1.13. Түүмрийн эрсдэл бүхий газарт шороон болон халзан зурвас байгуулна.

**Зорилго 2.** Хог хаягдлын менежментийг сайжруулж хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулна.

2.1. Иргэд хог хаягдлаа дахивар, аюултай, энгийн гэсэн ангиллаар зориулалтын нэгт санд ангилан хаях дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

2.2. Иргэдийн экологийн боловсрол, хүмүүжил, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хогийн эх үүсвэрт нь ангилах ажлыг эхлүүлж, хэрэгжүүлнэ.

2.3. Сууцны төвийн задгай хогийг дарж, булшилж, нэгдсэн хогийн цэг байгуулна.

2.4. Хог хаягдлын менежментийг сайжруулж, дахин боловсруулж ашиглана.

2117144056  
ХТҮ4037 9030891

2.7. Сумын төвийн болон Ялалт багийн гэр хорооллын айл өрхүүдийг нэгдсэн байдлаар био 10-той болгоно.

### ТАВ. СУМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Иргэдийн ая тухтай, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж, дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилго 1. Сумандаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх зорилгоор дэд бүтцийг бий болгох, жижиг дундын зээл, бусад хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжинэ.

1.1 Чойбалсан хот Халхгол сум чиглэлийн 270 км хатуу хучилттай авто замтай болно.

1.2 Сумын онгоцны буудлын талбайг шинэчилнэ.


1.3 Хамардавааны замын үерийн далан суваг, ус зайлуулах байгууламжтай болно.

1.4 Сумын төв доторх зам засварын ажлыг эхлүүлнэ.

1.5 Сумын төв ХЦ-ийн 0198 дугаар ангийг холбосон хатуу хучилттай авто замтай болно.

1.7 Сумын төв, Ялалт багийн гэр хорооллын айл өрхийн хашааг жигдрүүлэхийг бодлогоор дэмжинэ.

1.8 Жижиг дунд үйлдвэрлэлийн барилгыг засварлана.



\_\_оОо\_\_